

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/029/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: [adiyasuren@audit.gov.mn](mailto:adiyasuren@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

додб.од. 25 № 01/174

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.БАТТӨМӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв буурч батлагдсан нь байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, санхүүжилт, орлогын эх үүсвэрийг зөв зохион байгуулан, нэн тэргүүнд эмч, ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх, эм эмнэлгийн хэрэгслийн өр төлбөрийг бууруулах зэрэг арга хэмжээг авч ажиллах талаар Эрүүл мэндийн яамны 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 2/4931 дүгээр албан бичгээр ажлын чиглэл ирсэн байна.

Иймд дээрх нөхцөл байдлаас шалтгаалж 2025 оны 10, 11, 12 дугаар сарын 129,545.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоогүй авлага үүссэн байна.

**Аудитын гол асуудал**

Бүгд найрамдах Солонгос Улсад үйлдвэрлэсэн серажим массажны болон татлагын орыг Био медикал инженеринг ХХК-иас 24,800.0 мянган төгрөгөөр худалдан авч тайлант онд нийт 160 өвчтөнд үйлчилгээ үзүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

4106020193

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт бүхий нийт 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 90 хувиар үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>459,184,975.81</b>	<b>414,913,677.06</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>670,805.33</b>	<b>167,897,572.97</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>670,805.33</b>	<b>167,897,572.97</b>
3121	Төгрөг	670,805.33	167,897,572.97
31211	Төрийн сангийн харилцах	670,805.33	167,897,572.97
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>373,112,795.38</b>	<b>131,795,015.23</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,636,573.97	2,250,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>371,476,221.41</b>	<b>129,545,015.23</b>
3351	Байгууллагаас авах авлага	371,476,221.41	129,545,015.23
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>85,401,375.10</b>	<b>115,221,088.86</b>
351	Түүхий эд материал	25,765,409.85	57,443,041.64
35110	Тусгай зориулалттай материал	10,164,440.00	17,630,240.00
35130	Эм боох материал	15,600,969.85	39,812,801.64
354	Хангамжийн материал	59,635,965.25	57,778,047.22
35410	Бичиг хэргийн материал	1,289,300.00	1,289,300.00
35420	Аж ахуйн материал	57,743,301.25	54,922,427.22
35460	Хүнсний материал	603,364.00	1,566,320.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>791,963,736.55</b>	<b>753,377,912.64</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>791,963,736.55</b>	<b>753,377,912.64</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>783,487,736.46</b>	<b>745,019,912.51</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,197,006.00	493,840,806.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(120,359,982.60)	(142,707,852.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	308,179,366.47	289,529,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(76,158,368.54)	(89,323,789.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	328,424,050.26	366,980,050.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(131,161,983.91)	(184,958,432.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,902,430.00	29,902,430.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,238,614.71)	(19,633,165.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,050,000.00	2,780,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,006,666.51)	(2,050,000.00)
39217	Ном	660,500.00	660,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>8,476,000.09</b>	<b>8,358,000.13</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	8,794,000.00	8,794,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(317,999.91)	(435,999.87)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,251,148,712.36</b>	<b>1,168,291,589.70</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,989,029.74</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,989,029.74</b>	<b>00.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>2,989,029.74</b>	<b>00.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	293,577.74	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,695,452.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,248,159,682.62</b>	<b>1,168,291,589.70</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,248,159,682.62</b>	<b>1,168,291,589.70</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	220,397,712.25	220,397,712.25
51101	Өмч: - төрийн	220,397,712.25	220,397,712.25
512	Хуримтлагдсан үр дүн	862,162,978.85	782,294,885.93
51210	Өмнөх үеийн үр дүн	862,162,978.85	862,162,978.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(79,868,092.92)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,598,991.52	165,598,991.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,251,148,712.36</b>	<b>1,168,291,589.70</b>

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,748,859,554.46</b>	<b>1,393,190,885.45</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>357,538,894.01</b>	<b>68,776,561.15</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>357,538,894.01</b>	<b>68,776,561.15</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	327,263,059.67	52,765,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	370,758.00	11,216,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	326,892,301.67	41,549,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	30,275,834.34	16,011,561.15
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,391,320,660.45</b>	<b>1,324,414,324.30</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>602,400.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	602,400.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>46,250,600.00</b>	<b>54,158,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,250,600.00	54,158,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,344,467,660.45</b>	<b>1,270,256,024.30</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,344,467,660.45	1,270,256,024.30
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,244,587,709.93</b>	<b>1,457,048,317.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,244,587,709.93</b>	<b>1,457,048,317.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,243,953,692.18</b>	<b>1,424,078,936.05</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>782,350,653.90</b>	<b>907,822,479.65</b>
210101	Үндсэн цалин	401,473,420.24	488,798,078.67
210102	Нэмэгдэл	312,477,613.66	320,189,575.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,762,000.00	27,000,000.00
210104	Урамшуулал	60,637,620.00	71,834,825.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>86,238,266.53</b>	<b>93,505,534.86</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,465,091.74	62,939,644.92
210202	Тэтгэмжийн даатгал	7,874,164.05	9,007,836.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,633,779.71	5,447,891.25
210204	Ажилгүйдлийн даатгал	3,244,481.61	3,180,163.79
210205	Эрүүл мэндийн даатгал	13,020,749.42	12,929,998.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,116,582.25</b>	<b>43,718,918.83</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,745,782.25	15,094,118.83
210302	Түлш, халаалт	28,124,800.00	28,124,800.00
210303	Цэвэр, бохир ус	246,000.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>73,456,516.89</b>	<b>81,120,497.33</b>
210401	Бичиг хэрэг	5,627,500.00	5,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	41,341,279.00	38,052,109.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,621,316.00	5,214,398.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,852,450.00	9,970,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,013,971.89	22,883,990.33
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>93,217,775.40</b>	<b>72,824,036.37</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,117,849.40	48,979,292.37
210502	Хоол, хүнс	18,706,626.00	21,270,744.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,393,300.00	2,574,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>54,821,474.08</b>	<b>49,767,183.70</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,298,341.37	3,445,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,723,132.71	12,802,383.70
210604	Урсгал засвар	39,800,000.00	33,519,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,529,700.00</b>	<b>4,846,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,529,700.00	4,846,200.00

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,528,000.00</b>	<b>1,989,057.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,466,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	100,000.00
210807	Газрын төлбөр	162,000.00	81,057.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>102,694,723.13</b>	<b>168,485,028.31</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,444,290.00	56,969,404.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,250,433.13	111,515,623.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>634,017.75</b>	<b>32,969,381.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>27,530,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,082,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	19,448,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>634,017.75</b>	<b>5,439,381.17</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	634,017.75	5,439,381.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>504,271,844.53</b>	<b>(63,857,431.77)</b>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,105,242.41	16,010,661.15
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,083,333.56	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	22,021,908.85	16,010,661.15
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(23,105,242.41)	(16,010,661.15)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>481,166,602.12</b>	<b>(79,868,092.92)</b>

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,036,907,751.04</b>	<b>1,577,586,530.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>370,758.00</b>	<b>11,216,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>370,758.00</b>	<b>11,216,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>370,758.00</b>	<b>11,216,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	370,758.00	11,216,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,036,536,993.04</b>	<b>1,566,370,530.48</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	602,400.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	602,400.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>46,250,600.00</b>	<b>54,158,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,250,600.00	54,158,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>989,683,993.04</b>	<b>1,512,212,230.48</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	989,683,993.04	1,512,212,230.48
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,136,944,489.66</b>	<b>1,378,979,862.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,136,944,489.66</b>	<b>1,378,979,862.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,136,310,471.91</b>	<b>1,346,010,481.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>772,296,353.66</b>	<b>908,729,483.42</b>
210101	Үндсэн цалин	337,595,752.48	489,705,082.44
210102	Нэмэгдэл	344,724,803.35	320,189,575.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,120,900.00	27,000,000.00
210104	Урамшуулал	81,854,897.83	71,834,825.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>97,635,563.00</b>	<b>93,530,534.86</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,734,163.00	62,964,644.92
210202	Тэтгэмжийн даатгал	7,591,400.00	9,007,836.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,331,400.00	5,447,891.25
210204	Ажилгүйдлийн даатгал	3,795,700.00	3,180,163.79
210205	Эрүүл мэндийн даатгал	15,182,900.00	12,929,998.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,116,582.25</b>	<b>43,718,918.83</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,391,782.25	15,094,118.83
210302	Түлш, халаалт	28,124,800.00	28,124,800.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>70,329,443.00</b>	<b>70,961,959.00</b>
210401	Бичиг хэрэг	6,352,500.00	5,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	38,645,827.00	40,747,561.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,621,316.00	5,214,398.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,659,300.00	10,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,050,500.00	10,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>70,990,220.00</b>	<b>102,699,824.16</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,932,520.00	72,966,124.16
210502	Хоол, хүнс	19,155,700.00	22,233,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,902,000.00	7,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>52,376,400.00</b>	<b>62,340,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,286,400.00	15,340,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,870,000.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	40,220,000.00	40,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,529,700.00</b>	<b>4,846,200.00</b>

**Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	5,529,700.00	4,846,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,528,000.00</b>	<b>1,989,057.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,466,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00
210807	Газрын төлбөр	162,000.00	81,057.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,508,210.00</b>	<b>57,194,404.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,508,210.00	57,194,404.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>634,017.75</b>	<b>32,969,381.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>27,530,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,082,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	19,448,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>634,017.75</b>	<b>5,439,381.17</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	634,017.75	5,439,381.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(100,036,738.62)</b>	<b>198,606,667.64</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>19,385,000.00</b>	<b>31,379,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,385,000.00</b>	<b>31,379,900.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	19,385,000.00	31,379,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,385,000.00	31,379,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(19,385,000.00)</b>	<b>(31,379,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(119,421,738.62)</b>	<b>167,226,767.64</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	120,092,543.95	670,805.33
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	670,805.33	167,897,572.97

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>C01</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>172,653,598.99</b>	<b>(96,292,534.35)</b>	<b>296,758,776.89</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	220,397,712.25	172,653,598.99	(96,292,534.35)	296,758,776.89
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(11,102,658.15)	(11,102,658.15)
<b>C08</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>165,598,991.52</b>	<b>862,162,978.85</b>	<b>1,248,159,682.62</b>
<b>D01</b>	<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>165,598,991.52</b>	<b>862,162,978.85</b>	<b>1,248,159,682.62</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	862,162,978.85	1,248,159,682.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(79,868,092.92)	(79,868,092.92)
<b>D09</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>165,598,991.52</b>	<b>782,294,885.93</b>	<b>1,168,291,589.70</b>

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,874,308,500.00</b>	<b>1,572,147,149.31</b>	<b>302,161,350.69</b>	<b>83.9</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>54,158,300.00</b>	<b>48,718,918.83</b>	<b>5,439,381.17</b>	<b>90.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	54,158,300.00	48,718,918.83	5,439,381.17	90.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,811,397,400.00</b>	<b>1,515,346,230.48</b>	<b>296,051,169.52</b>	<b>83.7</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,811,397,400.00	1,515,346,230.48	296,051,169.52	83.7
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>8,752,800.00</b>	<b>8,082,000.00</b>	<b>670,800.00</b>	<b>92.3</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,752,800.00	8,082,000.00	670,800.00	92.3
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,874,308,500.00</b>	<b>1,404,920,381.67</b>	<b>469,388,118.33</b>	<b>75.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,874,308,500.00</b>	<b>1,404,920,381.67</b>	<b>469,388,118.33</b>	<b>75.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,846,226,500.00</b>	<b>1,377,390,381.67</b>	<b>468,836,118.33</b>	<b>74.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,133,796,900.00</b>	<b>908,729,483.42</b>	<b>225,067,416.58</b>	<b>80.1</b>
210101	Үндсэн цалин	681,796,900.00	489,705,082.44	192,091,817.56	71.8
210102	Нэмэгдэл	320,000,000.00	320,189,575.05	-189,575.05	100.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,000,000.00	27,000,000.00	0.00	100.0
210104	Урамшуулал	105,000,000.00	71,834,825.93	33,165,174.07	68.4
210105	Гэрээт ажлын хөлс			0.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>146,759,600.00</b>	<b>93,530,534.86</b>	<b>53,229,065.14</b>	<b>63.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	95,319,600.00	62,964,644.92	32,354,955.08	66.1
210202	Тэтгэмжийн даатгал	11,520,000.00	9,007,836.72	2,512,163.28	78.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,120,000.00	5,447,891.25	5,672,108.75	49.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,760,000.00	3,180,163.79	2,579,836.21	55.2
210205	Эрүүл мэндийн даатгал	23,040,000.00	12,929,998.18	10,110,001.82	56.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,158,300.00</b>	<b>43,718,918.83</b>	<b>5,439,381.17</b>	<b>88.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,533,500.00	15,094,118.83	4,439,381.17	77.3
210302	Түлш, халаалт	28,124,800.00	28,124,800.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	500,000.00	1,000,000.00	33.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>98,703,400.00</b>	<b>70,961,959.00</b>	<b>27,741,441.00</b>	<b>71.9</b>
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	63,673,900.00	40,747,561.00	22,926,339.00	64.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,029,500.00	5,214,398.00	4,815,102.00	52.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0

**Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>125,801,600.00</b>	<b>102,699,824.16</b>	<b>23,101,775.84</b>	<b>81.6</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	96,067,900.00	72,966,124.16	23,101,775.84	76.0
210502	Хоол, хүнс	22,233,700.00	22,233,700.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>93,000,000.00</b>	<b>93,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	46,000,000.00	46,000,000.00	0.00	100.0
210602	Тавилга			0.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	40,000,000.00	40,000,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,900,000.00</b>	<b>4,846,200.00</b>	<b>1,053,800.00</b>	<b>82.1</b>
210702	Дотоод албан томилолт	5,900,000.00	4,846,200.00	1,053,800.00	82.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,238,000.00</b>	<b>1,989,057.00</b>	<b>1,248,943.00</b>	<b>61.4</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,176,000.00	1,008,000.00	1,168,000.00	46.3
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	100,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	162,000.00	81,057.00	80,943.00	50.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>189,868,700.00</b>	<b>57,914,404.40</b>	<b>131,954,295.60</b>	<b>30.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	189,868,700.00	57,914,404.40	131,954,295.60	30.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,082,000.00</b>	<b>27,530,000.00</b>	<b>552,000.00</b>	<b>98.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,082,000.00</b>	<b>27,530,000.00</b>	<b>552,000.00</b>	<b>98.0</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,082,000.00	8,082,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000,000.00	19,448,000.00	552,000.00	97.2
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>670,805.33</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>167,897,572.97</b>		

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 24,182.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3,499.1 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан мөрөнд буруу тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд бараа материал акталсан зардлыг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 3,147.2 мянган төгрөг, багаж хэрэгслийн зардалд 350.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 1,146.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй гарсан зардал 4,671.3 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 529.2 мянган төгрөгийг тус тус буруу тайлагнасан байна.

Бараа материалын тодруулга тайланд Төв аймгийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн 10,816.4 мянган төгрөгийн бараа материалыг хандив тусламжийн мөрөнд буруу тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 3.2 мянган төгрөгийн эмийн зардлыг бага үнэтэй түргэн элэгдэх зардалд бүртгэсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 20.0 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ зардлыг цалингийн зардалд тохируулан бичиж тайланг зөрүүтэй бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2 “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасны дагуу санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар нийт 12,359.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 11,099.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1,260.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 12,359.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 12,445.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 10,338.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т “хариуцлагатай байх” гэж заасантай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн: Жолоочийн тооцооны хуудас, шатахууны зарцуулалтын тайлан гаргаж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоодын аудитын газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 33-01-320 дугаартай улсын байцаагчийн тогтоосон 761.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тус эрүүл мэндийн төвийн батлагдсан цалингийн зардлаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан зардлыг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага өгөв.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 14,382.1 мянган төгрөгийн актын төлбөрийн цалингийн зардлаас төлж, алба хаагчдаас 5-12 сарын хугацаанд 13,122.1 мянган төгрөг суутгаж, 1,260.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагын бүрэн төлж барагдуулах.

### **3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 284 ширхэг 165,147.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч

этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй байна

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх.

#### **4. Зардлын данстай асуудалтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас 720.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар"-тай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал ашиглах заавар журмыг дагаж мөрдөх, зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгийг худалдан авсан мөрөнд буруу тайлагнасан	1	3,499.1			1	3,499.1	1	3,499.1		
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд бараа материал акталсан зардлыг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 3,147.2 мянган төгрөг, багаж хэрэгслийн зардалд 350.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 1,146.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй гарсан зардал 4,671.3 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 529.2 мянган төгрөгийг тус тус буруу тайлагнасан байна.	1	9,843.7			1	9,843.7	1	9,843.7		
3	Бараа материалын тодруулга тайланд Төв аймгийн эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжүүлэн 10,816.4 мянган төгрөгийн өгсөн материалыг хандив тусламжийн мөрөнд буруу тайлагнасан.	1	10,816.4			1	10,816.4	1	10,816.4		
4	Санхүүгийн үр дүнгийн тайланд 3.1 мянган төгрөгийн эмийн зардлыг бага үнэтэй түргэн элэгдэх зардалд бүртгэсэн байна.	1	3.1			1	3.1	1	3.1		
5	Санхүүгийн үр дүнгийн тайланд 19.9 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ зардлыг цалингийн зардалд тохируулан бичиж тайланг зөрүүтэй бүртгэснийг	1	19.9			1	19.9	1	19.9		
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>24,182.4</b>			<b>5</b>	<b>24,182.4</b>	<b>5</b>	<b>24,182.4</b>		

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1							1					
2	Төв аймгийн санхүүгийн хяналт, дотоодын аудитын газрын 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 33-01-152 дугаартай улсын ахлах байцаагчийн тогтоосон нийт 18 ажилтанд 990.0 мянган төгрөг, мөн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 33-01-320 дугаартай улсын байцаагчийн тогтоосон 761.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тус төвийн батлагдсан цалингийн зардлаас төлсөн.	1	761.5			1	761.5							
3	2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 14,382.1 мянган төгрөгийн актын төлбөрийн цалингийн зардлаас төлж алба хаагчдаас 5-12 сарын хугацаанд 13,122.1 мянган төгрөг суутгаж, 1,260.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан.	1	1,260.0						1	1,260.0				
4	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 284 ширхэг 165,147.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1							1					
5	Бараа үйлчилгээний бусад зардлаас 720.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.	1							1					

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	Анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 10,338.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	1	10,338.0			1	10,338.0						
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>12,359.5</b>			<b>2</b>	<b>11,099.5</b>	<b>4</b>	<b>1,260.0</b>				<b>0</b>

Төв аймгийн Баянчадмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 140 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 31 мэдээлэл байна. Шилэн дансны тухай хуулийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1.373.218.9 мянган төгрөгийн 29 гүйлгээ, зарлагын 100.799.8 мянган төгрөгийн 8 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 34.344.8 мянган төгрөгийн 5 гүйлгээ байршуулаагүй. Мөн шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.	1	1,508,363.6	-	-	1	1,508,363.6	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,508,363.6</b>			<b>1</b>	<b>1,508,363.6</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,508,363.6</b>			<b>1</b>	<b>1,508,363.6</b>		



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 57-20810579-ТӨА-2026/029/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоодын аудитын газрын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 33-01-152 дугаартай улсын ахлах байцаагчийн тогтоосон нийт 18 ажилтанд 990.0 мянган төгрөг, мөн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 33-01-320 дугаартай улсын байцаагчийн тогтоосон 761.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг тус Эрүүл мэндийн төвийн батлагдсан цалингийн зардлаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Баттөр, нягтлан бодогч Ж.Баярмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.МӨНХТУЯА



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 56-20810579-ТӨА-2026/029/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 10,338,000 /арван сая гурван зуун гучин найман мянга/ төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэлийг бүрэн хөтлөх, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Баттөр, нягтлан бодогч Ж.Баярмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨБСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 55-20810579-ТӨА-2026/029/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 140 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 31 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,373,218.9 мянган төгрөгийн 29 гүйлгээ, зарлагын 100,799.8 мянган төгрөгийн 8 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 34,344.8 мянган төгрөгийн 5 гүйлгээ, шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Баттөр, нягтлан бодогч Ж.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)